



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 21

Номгон

Аж ахуйн нэгж, байгууллагын  
2017 оны санхүүгийн тайлангийн  
нэгтгэлийг дэмжих тухай

Монгол Улсын Сангийн сайдын 2015 оны 215 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн ажлын үр дүнг үнэлж, урамшуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.3.2 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын 2017 оны санхүүгийн тайлангийн нэгтгэл, шинжилгээ и-баланс програмд үндэслэн боловсруулснаар дэмжсүгэй.
2. Аж ахуйн нэгж, байгууллагын тайланг хууль журмын дагуу гаргаж байгааг сайтар шалгаж, санхүүгийн шинжилгээ хийж, сургалт мэдээллийг тогтмолжуулж, тайлан мэдээг хуулийн хугацаанд ирүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага тооцож аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР